

ДЭМБ-ЫН ТАМХИНЫ
ХЯНАЛТЫН СУУРЬ
КОНВЕНЦ



12 дугаар зүйлийг
хэрэгжүүлэх
Удирдамж



FCTC

WHO FRAMEWORK CONVENTION
ON TOBACCO CONTROL

ДЭМБ-ЫН ТАМХИНЫ ХЯНАЛТЫН СУУРЬ КОНВЕНЦ

12 дугаар зүйлийг хэрэгжүүлэх удирдамж:

“БОЛОВСРОЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО, СУРГАЛТ БА ОЛОН НИЙТЭД МЭДЛЭГ ОЛГОХ”

Оролцогч талуудын Бага хурлын дөрөвдүгээр (шийдвэр дугаар FCTC/COP4(7))
хуралдаанаар баталсан.

Эх хувилбартай дараах хаягаар танилцана уу:

<https://fctc.who.int/publications/m/item/education-communication-training-and-public-awareness>

ДЭМБ-ЫН ТАМХИНЫ ХЯНАЛТЫН СУУРЬ КОНВЕНЦ

Оролцогч талуудын Бага хурлаас шийдвэрлэх нь:

ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенц (ТХСК)-ийн 12 дугаар зүйл (Боловсрол, харилцаа холбоо, сургалт ба олон нийтэд мэдлэг олгох)-ийг харгалзан,

ДЭМБ-ын ТХСК-ийн 12 дугаар зүйлийг хэрэгжүүлэх удирдамжийг боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай FCTC/COP2(14) шийдвэр, ажлын хэсэгт ажлаа үргэлжлүүлж, удирдамжуудын төслийг Оролцогч талуудын бага хурлын дөрөвдүгээр хуралдаанд танилцуулахыг үүрэг болгосон FCTC/COP3(11) шийдвэр зэргийг үндэслэн,

Энэхүү удирдамжийн зорилго нь Оролцогч талуудад ДЭМБ-ын ТХСК-ийн 12 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд туслахад орших ба энэхүү зүйлийн дагуу Оролцогч талуудын хүлээсэн үүргийг өргөжүүлэхэд чиглээгүй болохыг цохон тэмдэглэж,

1. ДЭМБ-ын ТХСК-ийн 12 дугаар зүйлийг хэрэгжүүлэх удирдамжийг хавсралт ёсоор БАТАЛСУГАЙ;
2. Конвенцийн Нарийн бичгийн даргын газарт дараах зүйлийг ДААЛГАСУГАЙ:
 - (1) ДЭМБ-ын ТХСК-ийн 12 дугаар зүйлийг хэрэгжүүлэх удирдамжтай холбоотой олон улсын мэдээний санг, боломжтой бол Оролцогч талуудын Бага хурлаас баталсан бүх удирдамжийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн шилдэг туршлага, арга хэрэгсэл, арга хэмжээний нэгдсэн мэдээний сангийн бүрэлдэхүүн хэсэг болгон боловсруулах, санхүүжүүлэх хувилбаруудыг тодорхойлох. Үр ашигтай байдлыг хангах үүднээс энэхүү мэдээний санг нэгэнт бүрдсэн Оролцогч талуудын тайлангийн мэдээний санд тулгуурлан боловсруулж, олон улсын холбогдох эх сурвалжийн бусад мэдээг харгалзах нь зүйтэй. Ингэхдээ Оролцогч талууд, холбогдох олон улсын байгууллагууд, нэн ялангуяа Тамхигүй санаачилга болон бусад холбогдох газруудаар нь дамжуулж ДЭМБ-аас дэмжлэг авч, хамтран ажиллах шаардлагатай.
 - (2) Тодорхой хугацааны дотор, боломжтой бол 60 хоногийн дотор тамхины боловсрол, харилцаа холбоо, сургалт ба олон нийтэд мэдлэг олгох талаарх олон улсын, бүс нутгийн, үндэсний эх сурвалжуудыг вэбсайтаар буюу бусад зохимжтой арга хэрэгслээр хүртээмжтэй болгох.
 - (3) Оролцогч талуудад олон нийтийн боловсрол, сургалтын үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж чадах төрийн ба төрийн бус байгууллагуудын жагсаалтыг вэбсайт дээр байршуулах.
3. Энэхүү удирдамжийг засч сайжруулах ажлыг эхлүүлэх эсэх асуудлыг зургаадугаар хуралдаанаар авч хэлэлцэхээр ШИЙДВЭРЛЭСҮГЭЙ.

ХАВСРАЛТ

ДЭМБ-ЫН ТХСК-ИЙН 12 ДУГААР ЗҮЙЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДАМЖ

БОЛОВСРОЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО, СУРГАЛТ БА ОЛОН НИЙТЭД МЭДЛЭГ ОЛГОХ

УДИРДАМЖИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ БА ЗАРЧИМ

Зорилго

Энэхүү удирдамж нь ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенци (ДЭМБ-ын ТХСК)-ийн 12 дугаар зүйл болон бусад холбогдох зүйлийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь Оролцогч талуудад туслах зорилготой болно. Удирдамжид тамхины хяналттай холбоотой асуудлаар олон нийтэд мэдлэг олгох боловсрол, харилцаа холбоо, сургалтын үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх арга хэмжээг санал болгосон. Удирдамжийг шинжлэх ухааны нотолгоо болон Оролцогч талуудын туршлагад тулгуурлан боловсруулсан бөгөөд конвенцийн дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, хариуцлагын өндөр стандарт тогтоох, Оролцогч талуудад боловсрол, харилцаа холбоо, сургалтаар дамжуулан хүн амын эрүүл мэндийг сайжруулахад нь туслахад чиглэсэн болно. Оролцогч талууд конвенцийн 2.1 дүгээр зүйлийн дагуу ТХСК, түүний протоколууд болон энэхүү удирдамжид санал болгосноос бусад арга хэмжээг нэмэлтээр хэрэгжүүлэх нь зүйтэй.¹

Зорилт

Энэхүү удирдамж нь дараах зорилттой. Үүнд:

- (a) Тамхины үйлдвэрлэл², хэрэглээ, тамхины утаанд өртөхтэй холбоотой эрүүл мэнд, нийгэм, эдийн засаг, орчны нөлөөллийн талаар хүн амд боловсрол олгох, мэдээлэл хүргэх, сургахад шаардлагатай хууль эрх зүйн, захиргааны, санхүүгийн болон бусад үр дүнтэй арга хэмжээг тодорхойлох;
- (b) Шинжлэх ухааны нотолгоо ба/буюу шилдэг туршлагад тулгуурлан эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх тогтвортой нөөц, дэд бүтэц бүрдүүлэх Оролцогч талуудын хүчин чармайлтыг удирдан чиглүүлэх.

Зарчим

Дараах үндсэн зарчимд тулгуурлан 12 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангана. Үүнд:

- (i) *Хүний суурь эрх, эрх чөлөөг хангах.* Тамхины үйлдвэрлэл, хэрэглээ, тамхины утаанд өртөхтэй холбоотой хор хөнөөл, тамхины хяналт болон тамхины хяналтыг үр дүнгүй болгоход чиглэсэн тамхи үйлдвэрлэгчдийн стратеги, үйл ажиллагааны талаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэхийн тулд боловсрол, харилцаа холбооны үйл ажиллагаа

¹ ДЭМБ-ын ТХСК вэбсайт (<https://fctc.who.int/>)-аас энэхүү удирдамжид хөндөгдсөн асуудлаар нэмэлт мэдээллийн эх сурвалжийг харна уу.

² Үүнд тамхины тариалалт, үйлдвэрлэл, маркетинг хамаарна.

хэрэгжүүлэх (12 дугаар зүйлд заасан) үүрэг нь ТХСК-д тусгагдсан ба амьд явах эрх, эрүүл амьдрах эрх, боловсрол эзэмших эрх зэрэг хүний суурь эрх, эрх чөлөөний тусгал болдог.³ 12 дугаар зүйлийг хэрэгжүүлэх мандатыг ДЭМБ-ын ТХСК-ийн бүхий л хэсэгт өргөнөөр тусгасан байна.⁴

- (ii) *Суурь эрх, эрх чөлөөнд заналхийлэхээс хамгаалах.* Засгийн газрын зүгээс хувь хүмүүсийн суурь эрх, эрх чөлөөнд заналхийлсэн аливаа үйлдлээс хамгаалах хууль эрх зүйн, захиргааны болон бусад үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.^{1,2}
- (iii) *Салбар хоорондын нягт хамтын ажиллагаа.* Шинэ болон альтернатив тамхин бүтээгдэхүүний хэрэглээтэй холбоотой хор хөнөөлийн талаар боловсрол, харилцаа холбоо болон олон нийтэд мэдлэг олгох үр дүнтэй хөтөлбөр хэрэгжүүлэх, тэдгээрийн өртөмтгий бүлгийн хүн амд үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх, тамхины хяналтыг үр дүнгүй болгоход чиглэсэн тамхи үйлдвэрлэгчдийн стратеги, үйл ажиллагааг хумихад конвенцийн 4.4 ба 5.2 дугаар зүйлд заасанчлан салбар хоорондын цогц арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай.
- (iv) *Нийгмийн эрүүл мэндийн бодлогыг тамхи үйлдвэрлэгчдийн ашиг сонирхлоос хамгаалах.* Нийгмийн эрүүл мэндийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг ТХСК-ийн 5.3 дугаар зүйл болон түүнийг хэрэгжүүлэх удирдамж, нэн ялангуяа үндсэн зарчим 1-д заасанчлан тамхи үйлдвэрлэгчдийн худалдааны болон бусад уламжлалт ашиг сонирхлоос хамгаалах шаардлагатай.
- (v) *Судалгаанд тулгуурласан нотолгоо⁵ ба шилдэг туршлага.* Улс орны нөхцөл байдалд нийцсэн судалгаанд тулгуурласан нотолгоо ба шилдэг туршлага нь тамхины хяналттай холбоотой асуудлаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх боловсрол, харилцаа холбоо, сургалтын

³ Эдгээр эрхийг олон улсын эрх зүйн олон баримт бичиг (Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 3 ба 25 дугаар зүйл, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дүрмийн Удиртгал хэсэг, Хүүхдийн эрхийн тухай конвенци, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэргийг устгах тухай конвенци, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай конвенци)-т хүлээн зөвшөөрсөн бөгөөд ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцийн Удиртгал хэсэгт албан ёсоор оруулж, олон улс орны Үндсэн хуульд тусгасан байдаг. Боловсрол эзэмших эрхийг Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын конвенцийн 13 дугаар зүйл, НҮБ-ын Нийгэм, эдийн засгийн зөвлөлийн 13 дугаар ерөнхий мэдэгдэл (E/C.12/1999/10)-д тодорхойлсон болно.

⁴ Эдгээр эрхийг ТХСК-ийн дараах зүйл заалтуудад тусгасан байна. Үүнд: 2 дугаар зүйл (Энэхүү конвенци болон бусад гэрээ, эрх зүйн баримт бичгүүдийн уялдаа холбоо), 3 дугаар зүйл (Зорилт), 4 дүгээр зүйл (Үндсэн зарчим), 5 дугаар зүйл (Ерөнхий үүрэг), 8 дугаар зүйл (Тамхины утаанд өртөхөөс хамгаалах тухай), 10 дугаар зүйл (Тамхин бүтээгдэхүүний орц, найрлагыг мэдээлэх журам), 11 дүгээр зүйл (Тамхин бүтээгдэхүүний сав, баглаа, боодол ба шошгололт), 14 дүгээр зүйл (Тамхинд донтох, тамхинаас гарахтай холбоотой эрэлтийг бууруулах арга хэмжээ), 17 дугаар зүйл (Эдийн засгийн хувьд тогтвортой бусад үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх тухай), 18 дугаар зүйл (Орчин ба хүмүүсийн эрүүл мэндийг хамгаалах тухай), 19 дүгээр зүйл (Хариуцлага), 20 дугаар зүйл (Судалгаа, тандалт, мэдээллийн солилцоо), 21 дүгээр зүйл (Тайлагналт ба мэдээллийн солилцоо), 22 дугаар зүйл (Шинжлэх ухаан, эрх зүй болон мэргэжлийн чиглэлээр хамтран ажиллах, холбогдох мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх тухай)

⁵ “Судалгаанд тулгуурласан” гэдэг нь боловсрол, харилцаа холбоо, сургалтын үйл ажиллагаа, хөтөлбөрт хамааралтай үнэн зөв, найдвартай мэдлэгийг олж авах системтэй, нарийвчилсан, бодит аргачлал ашиглах гэсэн утгатай болно. Энэхүү судалгаа нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: (а) нотолгоонд тулгуурласан, логиктой оюуны дүгнэлт хийх шат дараалсан үйл ажиллагаа байна; (б) дэвшүүлсэн асуултад тохирсон арга ашиглах; (в) найдвартай, бусад нөхцөл байдалд хамаатуулах боломжтой үр дүн гаргах ажиглалтын буюу туршилтын судалгааны загвар, арга хэрэгсэл ашиглах; (г) үр дүнг баталгаажуулахуйц тоо мэдээ, дүн шинжилгээ; (д) судалгааны үйл явц, үр дүн, ялангуяа үр дүнг хүн амын ямар хэсэгт хамаатуулах боломжтойг тодорхой, нарийвчилж тайлбарлах; (е) мэргэжил нэгтний үнэлгээний хэм хэмжээг хангах; (ж) шинжлэх ухааны мэдлэгт хувь нэмэр оруулах зорилгоор үр дүнг бусдад түгээх; (з) дахин дүн шинжилгээ хийх, давтах, үр дүнг цаашид ашиглах боломжийг олгох зорилгоор тоо мэдээг хүртээмжтэй болгох; (и) судалгааны ёс зүйг баримтлах; (к) тамхи үйлдвэрлэгчдийн худалдааны болон бусад уламжлалт ашиг сонирхлоос ангид байх.

хөтөлбөрийг боловсруулах, удирдах, хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Нөөцийн бололцоотой үед ийм төрлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн өмнө конвенцийн 20 дугаар зүйлд заасанчлан орон нутгийн, үндэсний, бүсийн ба/буюу олон улсын түвшинд урьдчилан туршиж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байх нь зүйтэй. Тухайн улсад нөөц хязгаарлагдмал, нотолгоо байхгүй бол конвенцийн 20 ба 22 дугаар зүйлд заасанчлан бусад ул орнуудад хийс судалгааны үр дүн, нотолгоог хөтөлбөр боловсруулахад ашиглаж болно.

- (vi) *Олон улсын хамтын ажиллагаа*. Конвенцийн 4.3, 5.5, 20 ба 22 дугаар зүйлд заасанчлан боловсрол, харилцаа холбоо, сургалтын хөтөлбөрийг боловсруулах, удирдах, хэрэгжүүлэх Оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэхэд олон улсын хамтын ажиллагаа, харилцан дэмжлэг туйлын чухал юм. Оролцогч талууд судалгаанд тулгуурласан үр дүн, шилдэг туршлагыг тогтмол тодорхойлж, хэрэгжүүлж, хоорондоо хуваалцах шаардлагатай.
- (vii) *Хэм хэмжээг өөрчлөх*. Тамхи, тамхин бүтээгдэхүүний тариалалт, үйлдвэрлэл, маркетинг, борлуулалт, тамхин бүтээгдэхүүний хэрэглээ, тамхины утаанд өртөхтэй холбоотой нийгэм, орчин, ёс заншлын хэм хэмжээ, тогтсон ойлголтыг өөрчлөх нь чухал юм.
- (viii) *Нөөцийн хүртээмж*. Тамхины хяналтын салбар хоорондын цогц боловсрол, мэдээллийн хөтөлбөрийг тогтвортой хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц бүрдүүлэх, үүний тулд конвенцийн 5.6 ба 26 дугаар зүйлд заасан хоёр ба олон талт санхүүжилтийн механизмыг ашиглах зайлшгүй шаардлагатай.
- (ix) *Бүх хүнтэй харилцаа холбоо тогтоох*. Конвенцийн 4.1 ба 12 дугаар зүйлд заасанчлан тамхины үйлдвэрлэл, хэрэглээ, тамхины утаанд өртөхтэй холбоотой эрүүл мэндийн, нийгэм-эдийн засгийн болон орчны үр дагавар, тамхинаас гарах, тамхигүй амьдрахын үр өгөөж, тамхи үйлдвэрлэгчийн тухай хүн бүрт үнэн зөв, цогц мэдээлэл хүргэж, хүн бүрийг мэдлэгтэй болгох зайлшгүй шаардлагатай.
- (x) *Үндсэн ялгааг харгалзах*. Нас, хүйс, шашин шүтлэг, ёс заншил, боловсрол, нийгэм-эдийн засгийн статус, бичиг үсэг тайлагдалт, хөгжлийн бэрхшээл зэрэгтэй холбоотой хүн амын бүлгүүдийн хоорондын үндсэн ялгааг харгалзах нь тамхины хяналтын боловсрол, харилцаа холбоо, сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд асар их ач холбогдолтой юм.
- (xi) *Иргэний нийгмийн идэвхтэй оролцоо*. Конвенцийн 4.7 дугаар зүйлд заасанчлан иргэний нийгмийн идэвхитэй оролцоо, түншлэл нь энэхүү удирдамжийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд туйлын чухал.

ОЛОН НИЙТЭД МЭДЛЭГ ОЛГОХ ДЭД БҮТЭЦ БҮРДҮҮЛЭХ

Суурь мэдээлэл

Олон нийт тамхины хяналтын талаар мэдлэгтэй байх нь нийгмийн өөрчлөлтийг бий болгоход амин чухал. Олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх арга хэрэгслүүд нь тамхины хэрэглээ, тамхины утаанд өртөхтэй холбоотой зан үйлийн хэм хэмжээг өөрчлөхөд ач холбогдолтой юм. Тамхины хяналтын цогц хөтөлбөр нь олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх тулгын гурван чулуу болсон

боловсрол, харилцаа холбоо, сургалтанд судалгаанд тулгуурласан арга хэрэгслүүдийг ашигладаг.

Олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх дэд бүтэц гэж боловсрол, харилцаа холбоо, сургалтын хөтөлбөрийг тогтвортой хэрэгжүүлэхэд шаардлагатай байгууллагын бүтэц, чадавхийг хэлнэ. Энэхүү дэд бүтэц нь мэдлэг бий болгох, судалгааны үр дүн ба шилдэг туршлагыг зорилтот хүн амд хэрэгтэй, ойлгомжтой мэдээлэл болгон хувиргах, холбогдох мэдээллийг зорилтот хүн амд хүргэх, улмаар уг мэдээллийн мэдлэг, хандлага, зан үйлд үзүүлэх нөлөөг хянах боломж олгодог байна.

Дэд бүтэц нь үндэсний зохицуулалтын үр дүнтэй механизмд тулгуурлах ба уламжлалт бүтэц зэрэг орон нутгийн, үндэсний буюу бүс нутгийн онцлогийг харгалзан хот, хөдөөгийн хүн амын бүлгүүдэд хүрч үйлчилнэ.

Зөвлөмж⁶

Оролцогч талууд тамхины хэрэглээ, тамхины утаанд өртөх явдлаас сэргийлэх, бууруулах, устгахын тулд боловсрол, харилцаа холбоо, сургалтыг дэмжих дэд бүтэц бүрдүүлж, түүнийг олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, нийгмийн өөрчлөлтийг хөхиүлэн дэмжихэд үр дүнтэй ашиглах шаардлагатай.

Хэрэгжүүлэх арга зам⁷

Оролцогч талууд үндэсний нөхцөл байдал, тэргүүлэх чиглэл, нөөцийг харгалзан дараах арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй.

Конвенцийн 5.2(а)-д заасанчлан зохицуулалтын механизм бүрдүүлэх буюу хариуцах эзнийг тохоон томилно. Тамхины хяналтын ерөнхий стратеги, төлөвлөгөөний хүрээнд конвенцийн 12 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн оновчтой төлөвлөлт, удирдлага, хүрэлцэхүйц санхүүжилтийг баталгаажуулахын тулд зохицуулалтын механизм буюу хариуцах эзний чиг үүргийг тодорхой болгоно. Эдгээр нь тодорхой зорилт дэвшүүлж, хэрэгжилтэд нь тогтмол хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх замаар тамхины асуудлаарх боловсрол, харилцаа холбоо, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хурдасгах, зохицуулах, удирдан чиглүүлэх чиг үүрэгтэй байна.

Тамхины асуудлаарх боловсрол, харилцаа холбоо, сургалт хариуцсан албан тушаалтан байгууллагыг тодорхойлж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллагын чиг үүргийг тодорхой болгож салбар дундын болон салбар хоорондын (боловсрол, соёл, эрүүл мэндийн салбар, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байгууллага, санхүү, гааль, технологийн салбар г.м.) хамтын ажиллагааг хангана.

Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн гүйцэтгэх үүргийг конвенцийн 12 дугаар зүйлд тулгуурлан тодорхойлно.

Тамхины хяналтын цогц хөтөлбөрийн хүрээнд боловсрол, харилцаа холбоо, сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулна.⁸

⁶ Зөвлөмж гэдэг нь Оролцогч талуудад конвенцийн 12 дугаар зүйлийг хэрэгжүүлэхэд нь тус дөхөм болох улс төр, хөтөлбөрийн ерөнхий санал юм.

⁷ Хэрэгжүүлэх арга хэмжээ гэдэг нь зөвлөмжтэй нийцсэн хэмжиж болохуйц зорилт, үйл ажиллагаа юм. Энэ нь зөвлөмжийг амжилттай хэрэгжүүлэх зорилгоор санал болгож буй арга зам юм.

⁸ Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах асуудлуудын жишээг Хавсралт 1-ээс харна уу.

Хэрэгжүүлэгч болон хяналт тавих эрх бүхий байгууллагуудын хооронд зөвшилдөх уулзалтуудыг зохион байгуулах замаар конвенцийн 12 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийн талаар албан ёсны зөвшилцөлд хүрсэн байна. Хөтөлбөрийг судалгаанд тулгуурлаж хэрэгжүүлэхэд анхаарч, хэрэгцээ болон нөөцийг тодорхойлох нөхцөл байдлын дүн шинжилгээ, үнэлгээг тогтмол гүйцэтгэж, явцын зорилтуудын хэрэгжилт хангалтгүй бол тохируулга хийнэ. Үүний тулд тамхины хяналттай холбоотой судалгаа шинжилгээний ажлын өнөөгийн байдлыг тодорхойлох, орон нутгийн туршлагыг судлах үйл ажиллагаанд оролцох хувь хүн, байгууллагыг тодорхойлох, нөөцийн хуваарилалт, мэргэжил арга зүйн дэмжлэгийн чиглэлийг тогтоохын тулд судлагдаагүй асуудлуудыг илрүүлэхэд анхаарна.⁹

Орон нутгийн, үндэсний, бүсийн, олон улсын түвшинд хөтөлбөр хэрэгжүүлж, тогтвортой байдлыг нь хангах хүний нөөцийн, материаллаг болон санхүүгийн нөөц хуваарилж, шаардлагатай бол мэргэжил арга зүйн дэмжлэг авна. Хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангахын тулд санхүүгийн уламжлалт эх үүсвэрийг ашиглахын зэрэгцээ конвенцийн 26 дугаар зүйлд заасан бусад эх үүсвэрийг ашиглах боломжийг судална. Бусад эх үүсвэр бүрдүүлэх гэдэгт тамхинд ногдуулах онцгой албан татварыг нэмэгдүүлэх, тамхины тусгайлсан татвар ногдуулах, тусгай зөвшөөрлийн төлбөр хураамж авах, тамхины хяналтын боловсрол, харилцаа холбоо, сургалтын тусгай сан байгуулах зэрэг арга хэмжээ хамаарна. Санхүүжилтийн бүх механизмыг конвенцийн 5.3 дугаар зүйл, түүнийг хэрэгжүүлэх удирдамжид заасанчлан тамхи үйлдвэрлэгчийн нөлөөллөөс хамгаалах ёстой.

Тамхины хяналтын хөтөлбөрт логистикийн ба удирдлагын үр ашигтай дэмжлэг үзүүлнэ.

Тамхины хяналтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг шинэ, хөгжиж буй байгууллагуудад өөрийн эрхэм зорилгыг хэрэгжүүлэх, тогтвортой байдлыг хангахад нь туслах зорилгоор судалгаанд тулгуурласан сургалт, стратеги төлөвлөлтийн сургалт зохион байгуулна.

Тамхины хяналтын чиглэлээр орон нутгийн, үндэсний, бүсийн буюу олон улсын тоо мэдээ цуглуулж, судалгааны нэгдсэн мэдээний сан байгуулж, мэдээг олон нийтэд хүртээмжтэй болгоно.

БОЛОВСРОЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО, СУРГАЛТЫН ҮР ДҮНТЭЙ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ

Суурь мэдээлэл

Тамхины хяналттай холбоотой асуудлаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор харилцаа холбооны боломжит бүх арга хэрэгслийг ашиглахыг конвенцийн 12 дугаар зүйлд заасан. Тамхинд донтох, тамхинаас гарах асуудлаар боловсрол, харилцаа холбоо, сургалт зохион байгуулах талаар тодорхой чиглэлийг 14 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх удирдамжид танилцуулсан болно.

Боловсрол, харилцаа холбоо, сургалт нь тамхины хэрэглээ, тамхины утаанд өртөхтэй холбоотой олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, нийгмийн өөрчлөлтийг бий болгох арга зам нь болдог. Тамхины утаанд өртөхөөс

⁹ Сургалтад тулгуурласан стратеги, хөтөлбөрийн жишээг Хавсралт 2-оос харна уу.

хамгаалах, тамхигүй амьдралын хэв маягийг хөхиүлэн дэмжих, тамхичдад тамхинаас гарахад нь туслах, бусдыг нэн ялангуяа залуучуудыг тамхинд орохоос сэргийлэхэд чиглэсэн дэмжлэгт орчин бүрдүүлэх нийгмийн хэм хэмжээ нь нийт хүн амын эрүүл мэндийг сайжруулах боломж олгодог.

Хүмүүст сайн дураар шийдвэр гаргах, өөрийн зан үйлийг өөрчлөх, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр нийгмийн нөхцөл байдлыг өөрчлөх боломж олгоход чиглэсэн заах, сурах тасралтгүй үйл ажиллагааг тамхины хяналтын бодлогод **боловсрол** гэдэг.

Тамхины тариалалт, үйлдвэрлэл, маркетинг, хэрэглээ, тамхины утаанд өртөхтэй холбоотой асуудлаар нийгмийн тогтсон хандлагыг өөрчлөх, тамхины хэрэглээг буруушаах, тамхинд орохоос сэргийлэх, тамхинаас гарахыг хөхиүлэн дэмжих, дэмжлэгт орчин бүрдүүлэхэд олон нийтийг үр дүнтэй дайчлах, нийгмийн өөрчлөлтийн тогтвортой байдлыг хангахад тамхины хяналтын бодлого дахь **харилцаа холбоо** амин чухал үүрэгтэй.

Мэргэжлийн буюу практик ур чадвар, мэдлэг эзэмшүүлэх замаар тамхины цогц хөтөлбөрийн чадавхийг бүрдүүлэх, тогтвортой хадгалах үйл явцыг тамхины хяналтын бодлогод **сургалт** гэдэг.

Нийгмийн болон орчны өөрчлөлтийг хөхиүлэн дэмжих гэдэг нь нийгмийн бүлгүүд дэх зан үйлийн хэв маяг, нийгмийн болон орчны хэм хэмжээний харагдахуйц, тогтвортой өөрчлөлтийг дэмжсэн стратеги, үйл явц, үйл ажиллагаа юм.

Зөвлөмж

Оролцогч талууд бүхий л боломжит аргыг ашиглаж боловсрол, харилцаа холбоо, сургалтын тогтвортой байдлыг хангах замаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлж, дэмжлэгт орчин бүрдүүлж, зан үйлийн болон нийгмийн өөрчлөлтийг хөхиүлэн дэмжинэ.

Арга хэмжээ

Оролцогч талууд үндэсний нөхцөл байдал, тэргүүлэх чиглэл, нөөцийг харгалзан дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Ерөнхий

Боловсрол, харилцаа холбоо, сургалт, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх бусад хөтөлбөрийг судалгаанд тулгуурласан нэгдсэн зохицуулалттай арга барилаар төлөвлөн, хэрэгжүүлж, үнэлнэ.¹⁰

Зорилтот хүн амын оролцоог хангаж, хүн амын бүлгүүдийн хоорондын үндсэн ялгааг харгалзана.¹¹ Арга хэмжээг хэрэгжүүлэхдээ үр дүнтэй мессеж боловсруулж, ялгаварлан гадуурхахгүйгээр буюу нөөцийг тэгш бус хуваарилахгүйгээр хүн бүрт хүргэнэ. “Дараагийн үеийн тамхичид” хэмээн маркетингийн бай болгож байгаа залуучууд, нэн ялангуяа залуу эмэгтэйчүүд зэрэг тамхины хэрэглээ нь өсч буй хүн амын бүлгүүд болон бичиг үсэг тайлагдаагүй, боловсролгүй, бага боловсролтой, ядуу, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг анхаарлын гадна орхигддог бүлгүүдэд онцгой анхаарна. Түүнчлэн эцэг

¹⁰ Судалгаанд тулгуурласан стратеги, хөтөлбөрийн жагсаалтыг Хавсралт 2-оос харна уу.

¹¹ Зарчим (х)-ын дагуу

эхчүүд, багш нар, жирэмсэн эмэгтэйчүүдийн мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээ хэрэгжүүлнэ.

Тамхины үйлдвэрлэл, хэрэглээ, тамхины утаанд өртөхтэй холбоотой эрүүл мэнд, нийгэм-эдийн засаг, орчны сөрөг үр дагавар, хяналтын хүчин чармайлтыг үр дүнгүй болгох зорилгоор тамхи үйлдвэрлэгчдийн хэрэглэдэг арга, стратегийн талаар аль болох өргөн хүрээнд мэдээлэл хүргэж, тамхинаас гарах, тамхигүй амьдрахын үр өгөөжийг сурталчилна.¹²

Олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, хандлага, зан үйлийг өөрчлөх зорилттыг хэрэгжүүлэхийн тулд судалгаа шинжилгээ, явцын болон үр дүнгийн үнэлгээ хийнэ. Энэхүү судалгаа, үнэлгээ нь аль болох сүүлийн үеийн, нотолгоонд тулгуурласан байх ба шинэлэг арга, санааг хязгаарлах ёсгүй.

Орон нутгийн таслал, үндэсний болон бүс нутгийн шилдэг туршлагауудыг тодорхойлон, хэрэгжүүлж, судалгаанд тулгуурласан үр дүн, шилдэг туршлагыг конвенцийн 22 дугаар зүйлийн дагуу хуваалцах замаар олон улсын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжинэ.

Боловсрол, харилцаа холбоо, сургалт, судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, төрийн болон бусад байгууллага, конвенцийн 5.3 дугаар зүйл болон түүнийг хэрэгжүүлэх удирдамжийн зарчмуудыг хэрэгжүүлж, тамхи үйлдвэрлэгчийн шууд ба дам санхүүжилтийг хүлээн авахгүй байхыг баталгаажуулах арга хэмжээ авна.

Конвенцийн 8, 13 дугаар зүйл болон тэдгээрийг хэрэгжүүлэх удирдамжийн дагуу боловсрол, сургалтын үйл ажиллагаа явуулж буй барилга байгууламжид тамхины хэрэглээ, зар сурталчилгаа, дэмжлэг, ивээ тэтгэх үйл ажиллагаа, борлуулалтыг хориглоно.

Боловсрол, харилцаа холбоо, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулагчид дараах шалтгаанаар тамхи хэрэглэхээс татгалзах нь зүйтэй. Үүнд:

- (a) Тэд үлгэр дуурайлал үзүүлэх ёстой бөгөөд тамхи татсанаар түүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн таларх нийгмийн эрүүл мэндийн мессежийн хүчийг сулруулна.
- (b) Тамхины хэрэглээг хэвийн зүйл хэмээн хүлээн авах нийгмийн хэм хэмжээг өөрчлөх нь чухал бөгөөд боловсрол, харилцаа холбоо, сургалтыг зохион байгуулагчид энэ талаар үлгэр дуурайлал үзүүлэх ёстой.

Олон нийтэд боловсрол олгох ба харилцаа холбооны үйл ажиллагаа

Насан туршийн боловсролын аргыг ашиглан олон нийтэд боловсрол олгох хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.¹³

Кампанит ажил зэрэг харилцаа холбооны арга хэрэгсэл, арга хэмжээг хүн амын зорилтот бүлэг тус бүрийн хэрэгцээ, мэдлэг, хандлага, зан үйлд нийцүүлэн боловсруулж, тэдгээр нь дараах шаардлагыг хангасан байхад анхаарна:

- (a) Зорилтот хүн амд зохицсон байх;
- (b) Ойрхон давтамжтай/удаан үргэлжлэх байдлаар зохион байгуулагдсан байх;
- (c) Шинэлэг болон зорилтот мессеж агуулсан байх;

¹² Анхаарах асуудлын жагсаалтыг Хавсралт 3-аас харна уу.

¹³ Боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх байгууллагуудын жишиг жагсаалтыг Хавсралт 4-өөс харна уу.

- (d) Олон төрлийн арга, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглах¹⁴;
- (e) Амжилттай хэрэгжүүлсэн бусад кампанит ажлын туршлагаас ашиглах;
- (f) Нэгдсэн үнэлгээ хийх.

Олон нийтэд хүргэж буй мессежийн үр дүнтэй байдал, боломжтой бол судалгаа шинжилгээний үр дүнг харгалзан хамааралтай, цогц, сонирхолтой, бодит байдалд нийцсэн, үнэн зөв, ятгахуйц, өөрт итгэх итгэлийг бэхжүүлэхүйц мессежийг хүргэнэ. Өргөн хүрээний холбогдох мэдээллийг хамруулж эерэг болон сөрөг мессежийн гүйцэтгэх үүргийг орхигдуулахгүй байхад анхаарна.¹⁵

Зорилтот хүн амд мэдээлэл хүргэх хэвлэл мэдээллийн хамгийн тохиромжтой хэрэгслийг тодорхойлно. Харилцаа холбооны болон маркетингийн шинэ арга хэрэгсэл, шинэ технологийн боломж, эрсдэлийг судалж улмаар хэрэгдэх эсхүл татгалзах нь зүйтэй.

Хөгжиж буй улс орнуудын орлого багатай хотын болон хөдөөгийн хүн ам зэрэг бүлгүүдэд мэдээлэл хүргэхэд хэвлэл мэдээллийн зэрэгцээ олон нийтэд суурилсан (уламжлалт болон шинэ) харилцаа холбооны аргуудыг ашиглана.

Боловсрол, харилцаа холбооны кампанит ажлыг орлого багатай болон хөдөөгийн хүн ам зэрэг эмзэг бүлгийн хүн амд чиглүүлж, хамралтыг нь сайжруулна. Тамхины хяналтын чиглэлээр идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тамхи үйлдвэрлэгчидтэй холбоогүй төрийн бус байгууллага болон иргэний нийгмийн бусад гишүүдийг хөхиүлэн дэмжиж, төрийн зүгээс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдтэй хамтарсан буюу бие даасан боловсрол, харилцаа холбооны кампанит ажил зохион байгуулах замаар хүрч очих үйл ажиллагааг сайжруулж болно. Иргэний нийгмийн бие даан буюу хамтран хэрэгжүүлж буй кампанит ажлыг олон нийтийг дайчлах боловсролын хөтөлбөрүүдтэй хамтатган хэрэгжүүлж болно.

Олон нийтийн боловсрол, харилцаа холбооны үр дүнг хүн амын өөр өөр бүлгүүдэд үнэлж, ингэхдээ хүйс, зан заншил, боловсрол, нас, бичиг үсэг тайлагдалт зэрэг хүчин зүйлийн нөлөөг тооцно. Хөтөлбөрийг зорилтот бүлэг, нэн ялангуяа хэрэгцээ хамгийн ихтэй бүлгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэхийн тулд бүлэг тус бүрт үр дүнтэй байгаа үндсэн мессежийг судалгаанд тулгуурлан тодорхойлж, ашиглана.

Сургалт¹⁶

Сургалтын хэрэгцээг орон нутгийн, үндэсний, бүсийн болон олон улсын түвшинд тодорхойлж, холбогдох сургалтын төлөвлөгөө боловсруулж, тухайн нөхцөл байдал, хэрэгцээнд тохирсон сургалтын хөтөлбөрийг сонгон, хэрэгжүүлж, үнэлнэ. Хамралт, зохистой байдлыг сайжруулахын тулд сургалтын хөтөлбөрийг өөр өөр орчин нөхцөл (хот, хөдөө г.м.), сургалтын байгууллага (албан, албан бус, тасралтгүй г.м. сургалтын байгууллага), эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч (эмнэлэг, эрүүл мэндийн анхан шатны байгууллага, уламжлалт эмнэлэг г.м.) зэрэгт тохирохуйц байдлаар боловсруулж болно.

Эмч, эмнэлгийн ажилтан, олон нийтийн ажилтан, нийгмийн ажилтан, хэвлэл мэдээллийн ажилтан, багш, шийдвэр гаргагчид, уламжлалт анагаагч, шашны

¹⁴ Арга болон хэвлэл мэдээллийн арга хэрэгслийн жишиг жагсаалтыг Хавсралт 5-аас харна уу.

¹⁵ Харилцаа холбоо, боловсролын кампанит ажлын хүрээнд хамруулах мэдээллийн жишиг жагсаалтыг Хавсралт 3-аас харна уу.

¹⁶ ТХСК-ийн 14 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх удирдамжийн төсөл (баримт бичиг FCTC/COP/4/8) эрэлтийг бууруулах сургалтын талаар нэмэлт зөвлөмжийг толилуулсан болно.

номлогч, санхүү, гааль, хууль хэрэгжүүлэх байгууллагын ажилтан, тамхи тариалагчид болон бусад холбогдох гол гол мэргэжлийн хүмүүсийг сургалтад хамруулна.

Тамхины хяналтын үр дүнтэй арга хэмжээний талаар мэдлэг олгох, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэжлийн болон практик ур чадвар эзэмшүүлэх чиглэлээр холбогдох бүлгүүдийг тасралтгүй сургах судалгаанд тулгуурласан сургалтын хөтөлбөр боловсруулна. Сургалтын хөтөлбөрт тамхины хяналтын үйл ажиллагааг үр дүнгүй болгох зорилготой тамхи үйлдвэрлэгчдийн стратеги, үйл ажиллагааны талаар мэдээллийг тусгана.

Шинэлэг арга барилыг сургалтын хөтөлбөртэй хэрхэн уялдуулах¹⁷ зэргээр зорилтот бүлэг тус бүрт тохирсон сургалтын аргыг тодорхойлно.¹⁸

Тамхины үйлдвэрлэл, хэрэглээний хүний эрүүл мэнд, нийгэм, эдийн засаг, орчинд үзүүлэх сөрөг нөлөө зэрэг тамхины хяналтын олон талт асуудал, шинэ тамхин бүтээгдэхүүний талаарх мэдээллийг их сургууль, мэргэжлийн сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөрт тусгана. Холбогдох мэргэжлийн чиглэлээр тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн тасралтгүй хөгжлийн шаардлагад тамхины хяналтын боловсролын асуудыг тусгах чиглэлээр ахиц дэвшил гаргана.

Мэргэжлийн нийгэмлэг, оюутны байгууллага, албан ба албан бус боловсролын чиглэлээр идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг байгууллага зэрэг сургалт судалгааны байгууллагуудыг чадавх бэхжүүлэх, судалгаанд тулгуурласан сургалтын арга хэрэг боловсруулахад татан оролцуулна. Сургалтын үйл ажиллагаанд хувь нэмэр оруулж чадах албан тушаалтан, бодлого боловсруулагч, эрүүл мэндийн ажилтан, хэвлэл мэдээллийн ажилтан болон бусад нөлөө бүхий бүлгүүд, үлгэр дуурайлал болохуйц хүмүүсийг тодорхойлно.

Зорилтот бүлэг тус бүрт хамгийн тохиромжтой сургалтын аргуудыг тодорхойлохын тулд орон нутгийн, үндэсний, бүсийн болон олон улсын түвшинд сургалтын хөтөлбөрийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.¹⁹

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, тогтмол шинэчлэх зардлыг тусгах, тогтвортой хадгалах арга хэмжээ авна.

ИРГЭНИЙ НИЙГМИЙГ ТАТАН ОРОЛЦУУЛАХ НЬ

Суурь мэдээлэл

Конвенцийн Удиртгал болон 4.7 дугаар зүйлд төрийн бус байгууллага болон иргэний нийгмийн бусад гишүүдийн хувь нэмрийг цохон тэмдэглэсэн байна. Тамхины хяналтын үндэсний болон олон улсын хүчин чармайлтад иргэний нийгмийн оролцоо амин чухал юм.²⁰ Эдгээр нь конвенцийн 5.3 дугаар зүйлд заасанчлан тамхи үйлдвэрлэгчтэй ямар нэгэн холбоогүй болоход анхаарах шаардлагатай.

¹⁷ Шинэлэг арга барилын жишиг жагсаалтыг Хавсралт 7-оос харна уу.

¹⁸ Сургалтын төрлүүд (үүнд мөн тодорхой зорилтот бүлэгт зориулсан сургалтын жишээ)-ийн жишиг жагсаалтыг Хавсралт 6-аас харна уу.

¹⁹ Тодорхой зорилтот бүлэгт тохирсон сургалтын аргуудын жишиг жагсаалтыг Хавсралт 8-аас харна уу.

²⁰ Боловсрол, харилцаа холбоо, сургалт, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрт идэвхитэй оролцуулах нь зүйтэй иргэний нийгмийн гишүүдийн жишиг жагсаалтыг Хавсралт 9-өөс харна уу.

Зөвлөмж

Оролцогч талууд боловсрол, харилцаа холбоо, сургалтын хөтөлбөрийг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх бүхий л үе шатанд иргэний нийгмийн төлөөллийг идэвхитэй оролцуулна.

Оролцогч талууд зөвхөн тамхи үйлдвэрлэгчидтэй холбоогүй иргэний нийгмийн төлөөлөлтэй хамтран ажиллана.²¹

Арга хэмжээ

Оролцогч талууд үндэсний нөхцөл байдал, тэргүүлэх чиглэл, нөөцийг харгалзан дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Зорилтот бүлгүүдийн төлөөлөл зэрэг тамхины хяналтын чиглэлээр боловсрол, харилцаа холбоо, сургалтын үйл ажиллагаанд оролцдог иргэний нийгмийн төлөөлөлтэй тогтмол зөвшилцөж, хамтран ажиллаж, үр дүнтэй түншлэл тогтооно.

Тамхины хяналтын чиглэлээр боловсрол, харилцаа холбоо, сургалтын хөтөлбөр төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ хийхэд иргэний нийгмийг татан оролцуулж, төрийн зохицуулах механизм буюу хариуцсан албан тушаалтантай хамтран ажиллахад анхаарна.

Иргэний нийгэмтэй хамтран ажиллаж, нийгмийн уур амьсгалыг дараах чиглэлээр бүрдүүлнэ. Үүнд:

- (a) Тамхины хэрэглээг хянах олон нийтийн болон улс төрийн дэмжлэгийг хөхиүлэн дэмжих;
- (b) Засгийн газрын тамхины хяналтын үйл ажиллагааг дэмжих;
- (c) Хууль эрх зүйн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, эрх зүйн үр дүнтэй арга хэмжээг боловсруулж, хэрэгжилтийг хангах;
- (d) Тамхины хяналтын үйл ажиллагааг үр дүнтэй байлгах;
- (e) Тамхи үйлдвэрлэгчдийн зүгээс үзүүлэх нөлөөллийн талаарх ойлголтыг олон нийтийн дунд нэмэгдүүлэх;
- (f) Боловсрол, харилцаа холбоо, сургалт, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх кампанит ажлын хүчирхэг имижийг бүрдүүлэх;

Эрүүл мэндийн ажилтан, багш, сэтгүүлч болон бусад нөлөө бүхий мэргэжилтнүүдийг тодорхойлж, боловсрол, харилцаа холбоо, сургалтын үйл ажиллагааны нүүр царай, өөрчлөлтийг эхлүүлэгч болгон татан оролцуулна.

Тамхины хяналтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн бүлэг, холбоодод санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр тамхины хяналтын хөдөлгөөнийг бий болгон, бэхжүүлж, тамхины хяналтын үр дүнтэй холбоодыг хөхиүлэн дэмжинэ.

²¹ ТХСК-ийн 5.3 дугаар зүйлийг хэрэгжүүлэх удирдамжид заасанчлан үүнд тамхи үйлдвэрлэгчээс гадна тэдгээртэй нэгдмэл ашиг сонирхолтой байгууллага, хувь хүн хамаарна.

ТАМХИ ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ ХҮРТЭЭМЖТЭЙ БОЛГОХ

Суурь мэдээлэл

Тамхины компаниуд тамхины хяналтын үйл ажиллагаанд нөлөөлөх олон төрлийн тактик хэрэглэдэг талаар нотолгоо байдаг. Үүнд улс төрийн лобби, кампанит ажилд шууд буюу дам байдлаар хандив өгөх, эрдэм шинжилгээ судалгааны ажлыг санхүүжүүлэх, бодлогын ба хяналтын механизмд нөлөөлөх, олон нийттэй харилцах кампанит ажлын хүрээнд “байгууллагуудын нийгмийн хариуцлага”-ын санаачилга гаргах зэрэг стратеги хамаардаг. Конвенцийн 5.3 дугаар зүйлийг хэрэгжүүлэх удирдамж, нэн ялангуяа зөвлөмж 5.5-д оролцогч талууд тамхи үйлдвэрлэгчид болон тэдэнтэй нэгдмэл ашиг сонирхолтой этгээдээс гаргуулж авах мэдээллийг заасан байна. Конвенцийн 12 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүргийг биелүүлэхийн тулд энэхүү мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй болгож, бүх хөтөлбөрийг тамхи үйлдвэрлэгчдийн худалдааны болон бусад уламжлалт ашиг сонирхлоос хамгаалах шаардлагатай (5.3 дугаар зүйлд заасанчлан).

Зөвлөмж

Оролцогч талууд тамхи үйлдвэрлэгчдийн стратеги, үйл ажиллагаа²² болон тэдгээрийн бүрэлдэхүүнтэй¹ холбоотой үнэн зөв мэдээллийг олон нийтэд үнэгүй хүргэх, конвенцийн 12(с), 20.4(с) дүгээр зүйлийн дагуу тамхи үйлдвэрлэгчдийн талаарх өргөн хүрээний мэдээллийг боловсрол, харилцаа холбоо, сургалт, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрт тусгах шаардлагатай.

Арга хэмжээ

Оролцогч талууд үндэсний нөхцөл байдал, тэргүүлэх чиглэл, нөөцийг харгалзан дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Конвенцийн 12(с) дугаар зүйл, 5.3, 9, 10, 11, 13 дугаар зүйлийг хэрэгжүүлэх удирдамжид заасанчлан тамхи үйлдвэрлэгчдэд үнэн зөв, ил тод мэдээлэх үүрэг ногдуулах үр дүнтэй арга хэмжээ авна.

Тамхи үйлдвэрлэгчдийн стратеги, үйл ажиллагааны талаарх бүх мэдээллийг нээлттэй мэдээний сан, хяналт-шинжилгээний арга хэрэгсэл, судалгаанд тулгуурласан нийтлэл, мэдээллийн эх сурвалжуудын жагсаалтыг нийтлэх зэрэг аргаар олон нийтэд хүртээмжтэй болгоно.

Дараах чиглэлээр олон нийт болон засгийн газарт мэдээлэл, боловсролыг үр дүнтэй хүргэх боловсролын хөтөлбөр, харилцаа холбооны кампанит ажил, сургалтын арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд:

- (а) Боловсрол, харилцаа холбоо, сургалттай холбоотой ажилд нөлөөлөх тамхи үйлдвэрлэгчдийн санаачилгууд, тухайлбал тамхи үйлдвэрлэгчдийн санхүүжүүлж хэрэгжүүлдэг залуучуудын дунд тамхидалтаас сэргийлэх хөтөлбөр нь үр дүнгүй, сөрөг үр дүнтэй болох нь нотлогдсон бөгөөд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас нээлттэй буруушаасан байна.

²² ТХСК-ийн 5.3 дугаар зүйлийг хэрэгжүүлэх удирдамжийн зөвлөмж 5.2-ыг харна уу.

- (b) Оролцогч талуудын тамхины хяналтын бодлогод саад учруулах тамхи үйлдвэрлэгчдийн оролдлогууд.²³

Конвенцийн 12(с) зүйлд заасанчлан судлаачид, бусад холбогдох мэргэжилтнүүдийг сургах, тамхи үйлдвэрлэгчид болон тэдгээрийн бүтээгдэхүүний талаар холбогдох мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй болгох замаар тамхи үйлдвэрлэгчид, тэдгээрийн бүтээгдэхүүний хяналт-шинжилгээ, үнэлгээг үр дүнтэй болгох чадавхийг бэхжүүлэх арга замыг тодорхойлно.

Тамхи үйлдвэрлэгчид болон тэдгээрийн бүтээгдэхүүний талаарх мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй болгох харилцаа холбооны арга хэрэгслүүдийг боловсруулж, ашиглана.²⁴ Тухайн орны ёс заншилд нийцсэн байдал, хүртээмжийг харгалзан үүнд дараах арга хэрэгсэл хамаарна. Үүнд:

- (a) Тамхи үйлдвэрлэгчдийн тухай олон нийтийн мэдээний сан, тухайлбал Тамхи үйлдвэрлэгчдийн баримт бичгийн номын сан²⁵
- (b) Хэвлэл мэдээлэл ба /буюу орчин үеийн технологи ашиглан явуулах сөрөг сурталчилгааны кампанит ажил.

ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ БЭХЖҮҮЛЭХ

Суурь мэдээлэл

Оролцогч талуудад 12 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, тамхины үйлдвэрлэл, хэрэглээ, тамхины утаанд өртөхтэй холбоотой эрүүл мэндийн, нийгэм-эдийн засгийн болон орчны сөрөг үр дагаврыг амжилтай сөрөн зогсоход олон улсын хамтын ажиллагаа, харилцан дэмжлэг, мэдээлэл, мэдлэг, техникийн чадавхийн солилцоо амин чухал юм. Конвенцийг хэрэгжүүлэх үр дүнтэй арга хэмжээ, арга зам, удирдамж боловсруулахад олон улсын болон бүс нутгийн байгууллагуудтай хамтран ажиллах, хоёр ба олон талт санхүүжилтийн механизмыг ашиглах талаар хүлээсэн үүргийг конвенцийн 4.3, 5.4, 5.5, 20, 21, 22 дугаар зүйлүүдэд тусгасан болно.

Зөвлөмж

Оролцогч талууд олон улсын түвшинд хамтран ажиллаж, дэлхий нийтийн мэдлэгийг дээшлүүлэх шаардлагатай.

Арга хэмжээ

Оролцогч талууд үндэсний нөхцөл байдал, тэргүүлэх чиглэл, нөөцийг харгалзан дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Төлөвлөсөн ба/буюу хэрэгжүүлсэн олон нийтийн боловсролын хөтөлбөртэй холбоотой стратеги, тоо мэдээ, туршлагаасаа Оролцогч талуудтай хуваалцаж, практик ур чадвар, шилдэг туршлагаа солилцоно. Боломжтой бол конвенцийн хэрэгжилтийн талаар тайлагнах олон улсын механизмыг ашиглаж, хоёр ба олон талт хамтын ажиллагааны давуу талыг ашиглах нь зүйтэй.

²³ Конвенцийн 5.3 дугаар зүйлийг хэрэгжүүлэх удирдамжийн зөвлөмж 1.1, 1.2-т заасанчлан

²⁴ Конвенцийн 5.3 дугаар зүйлийг хэрэгжүүлэх удирдамжийн зөвлөмж 5.5-д заасанчлан

²⁵ <http://legacy.library.ucsf.edu/>

Салбар хоорондын хамтын ажиллагаанд тулгуурлан конвенцийг хэрэгжүүлнэ. Конвенцийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг тамхины хяналтын уулзалт болон эрүүл мэндийн салбараар хязгаарлахгүйгээр холбогдох олон улсын байгууллага, хурал зөвлөгөөн, иргэний нийгмийн түвшинд сурталчилна.

УДИРДАМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙХ БА НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

Суурь мэдээлэл

Конвенцийн 12 дугаар зүйлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нь олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэхэд зохистой арга хэрэглэж байгаа эсэхийг баталгаажуулахад амин чухал юм. Үндэсний болон олон улсын түвшинд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нь конвенцийн хэрэгжилтийн үр өгөөжийг улам дээшлүүлнэ. Улс орны түвшинд гарч байгаа ахиц дэвшлийг хэмжиж, шилдэг туршлагыг тодорхойлох замаар нөөцийн үр дүнтэй зарцуулалтыг хангана. Олон улсын түвшинд мэдээлэл, туршлага солилцох нь Оролцогч талуудад өөрийн стратеги, үйл ажиллагааг илүү үр өгөөжтэй болгох чиглэлээр сайжруулах боломж олгоно.

Зөвлөмж

Оролцогч талууд харилцаа холбоо, боловсрол, сургалтын үйл ажиллагаагаа үндэсний болон олон улсын түвшинд үнэлж, зохих өөрчлөлтийг оруулснаар конвенцийн дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, бусадтай харьцуулах, чиг хандлагыг тодорхойлох боломжтой болно.

Оролцогч талууд конвенцийн хэрэгжилтийг тайлагнахдаа боловсрол, харилцаа холбоо, сургалт, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагааны талаарх мэдээллийг тусгана.

Оролцогч талууд конвенцийн 12 дугаар зүйлийг хэрэгжүүлэх талаар олсон амжилтаа бусадтай хуваалцах зэргээ конвенцийн хэрэгжилтийн талаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх шаардлагатай. Түүнчлэн Оролцогч талууд конвенци нь тамхины хяналтын олон улсын үр дүнтэй стратеги мөн болохыг таниулах үйл ажиллагаа явуулах нь зүйтэй.

Арга хэмжээ

Оролцогч талууд үндэсний нөхцөл байдал, тэргүүлэх чиглэл, нөөцийг харгалзан дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Боловсрол, харилцаа холбоо, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ тогтмол хийж үр дүнг нь харьцуулалт хийх, хөтөлбөрийг сайжруулах зорилгоор ил тод мэдээлнэ.

Энэхүү удирдамжийн дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлэх хэрэгцээ, хэмжиж болохуйц зорилт, шаардлагатай нөөц, зорилт тус бүрийн хүрээнд гарсан ахиц дэвшил, үр дүн (зан үйлийн өөрчлөлт г.м.)-г үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхойлно.

Төрийн, төрийн бус болон бусад холбогдох байгууллагаар судалгаа хийлгэх замаар конвенцийн 12 дугаар зүйлийн хэрэгжилтийн талаар тоо мэдээ тогтмол цуглуулна.

Конвенцийн хэрэгжилтийн талаар тайлагнах арга хэрэгслийг ашиглан 12 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд боловсруулсан бодлого, бусад арга хэмжээний талаарх мэдээллийг баримтжуулж, бусадтай хуваалцана.²⁶

ҮНДСЭН МЕССЕЖ

ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцийн 12 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд Оролцогч талууд дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- (a) Боловсрол, харилцаа холбоо, сургалтыг дэмжих дэд бүтэц бүрдүүлж, чадавхийг бэхжүүлж, улмаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлж, нийгмийн өөрчлөлтийг хөхиүлэн дэмжих;
- (b) Олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, дэмжлэгт орчин бүрдүүлэх, зан үйлийн болон нийгмийн өөрчлөлтийг хөхиүлэн дэмжих бүхий л боломжит аргыг ашиглах;
- (c) Олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн холбогдох үе шатанд иргэний нийгмийг татан оролцуулах;
- (d) Боловсрол, харилцаа холбоо, сургалтын хөтөлбөрүүдэд тамхи үйлдвэрлэгчид, тэдгээрийн стратеги, бүтээгдэхүүний талаар өргөн хүрээний мэдээлэл тусгах;
- (e) Дэлхий нийтийн мэдлэгийг дээшлүүлэхийн тулд олон улсын түвшинд хамтран ажиллах;
- (f) Боловсрол, харилцаа холбоо, сургалтын үйл ажиллагаанд үндэсний болон олон улсын хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж харьцуулалт хийх, хандлагыг илрүүлэх боломж олгох, мөн шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг оруулах;
- (g) Конвенцийн хэрэгжилтийг хянах тайлагналтын механизмыг ашиглан боловсрол, харилцаа холбоо, сургалтын талаар мэдээлэх;
- (h) ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенци, түүний хяналт-шинжилгээний арга хэрэгслийг ашиглан түүний хэрэгжилтийн талаар олон нийтэд мэдээлэх, конвенцийн тамхины хяналтын олон улсын үр дүнтэй стратеги болох статусыг өсгөх арга хэмжээ хэрэгжүүлэх.

²⁶ Олон улсын түвшинд тайлагнах мэдээллийн жишиг жагсаалтыг Хавсралт 10-аас харна уу.

ХАВСРАЛТ 1

Тамхины хяналтын цогц хөтөлбөрийн хүрээнд боловсрол, харилцаа холбоо, сургалтын үйл ажиллагаа хэрэгжүүлэх төлөвлөгөөний жишиг хяналтын хуудас:

- Алсын харааг тодорхойлох;
- Эрхэм зорилгоо томъёолох;
- Зорилго, зорилтуудыг дэвшүүлэх;
- Зорилт тус бүрийг хэрэгжүүлэх стратеги, хүлээгдэж буй үр дүнг сонгох;
- Төсвийн төлөвлөгөө боловсруулах;
- Үйл ажиллагаа тус бүрийг хариуцах эзнийг тодорхойлох;
- Хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах нөөцийг тогтоох;
- Хэрэгжилтийн үр дүнг хэмжих ахиц дэвшлийн шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох;
- Хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;
- Үр дүнг тамхины хяналтын боловсрол, харилцаа холбоо, сургалтыг хариуцсан хувь хүн, хуулийн этгээд, эрх бүхий байгууллагуудад түгээх²⁷.

ХАВСРАЛТ 2

Судалгаанд тулгуурласан стратеги, хөтөлбөрийн жишиг хяналтын хуудас:

- Нөхцөл байдлын дүн шинжилгээ, хэрэгцээний үнэлгээ тогтмол хийх;
- Зорилтот бүлгүүдийг тодорхойлох;
- Зан үйлийн өөрчлөлтийн зорилтыг тодорхойлох;
- Шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох;
- Мессеж боловсруулж, турших;
- Хэрэгжүүлэх арга замыг сонгох;
- Санхүүжилт олох;
- Түншүүдийг тодорхойлох;
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;
- Төрийн болон бусад байгууллагуудын хоорондын зохицуулалтыг хангах;
- Үр дүнг түгээх.

²⁷ Энэхүү удирдамжийн 10 дугаар хэсэгт тайлбарласны дагуу

ХАВСРАЛТ 3

Боловсрол, харилцаа холбоо, сургалтын хөтөлбөрт анхаарах асуудлуудын жишиг жагсаалт:

- Тамхигүй амьдрал, тамхинаас гарахын үр өгөөж;
- Хүн амын өвчлөл, нас баралтад тамхины үзүүлэх нөлөөний талаарх тархварзүйн тоо мэдээ, шинэ тамхин бүтээгдэхүүний тухай мэдээлэл зэрэг тамхины тариалалт, үйлдвэрлэл, хэрэглээ, тамхины утаанд өртөхтэй холбоотой эрүүл мэндийн нөлөө;
- Эрүүл мэндтэй холбоотой зардал, бүтээмжийн алдагдал, эндэгдэл, орчны нөлөө, ядууралд үзүүлэх нөлөө зэрэг тамхины тариалалт, үйлдвэрлэл, хэрэглээтэй холбоотой эрүүл мэнд, нийгэм, орчин, эдийн засгийн зардал, үр дагавар;
- Конвенци, түүнийг хэрэгжүүлэх удирдамжууд зэрэг тамхи, тамхины хяналттай холбоотой орон нутгийн, үндэсний, бүсийн, олон улсын бодлого, тайлан;
- Тамхи үйлдвэрлэгчийн тамхины хяналтын хүчин чармайлтын үр дүнг бууруулахад чиглэсэн стратеги, үйл ажиллагаа, тамхи үйлдвэрлэгчийн санхүүжүүлсэн тамхины хяналтын арга хэмжээ (ж.нь, залуучуудад зориулсан кампанит ажил) үр дүнгүй болох тухай мэдээлэл;
- Тамхи донтолын үед зан үйлийн үр дүнтэй дэмжлэг (зөвлөгөө өгөх ур чадвар) үзүүлэх арга техник.

ХАВСРАЛТ 4

Боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх газруудын жишиг жагсаалт:

- Гэр;
- Сургууль, сургууль төст байгууламж, үүнд бага ба дунд сургууль, коллеж, их сургууль, тасралтгүй болон насан туршийн сургалтын хөтөлбөр;
- Спорт, амралтын газар;
- Ажлын байр;
- Эрүүл мэндийн байгууллага;
- Олон нийтийн байгууллага;
- Нөхөн сэргээх байгууллага.

ХАВСРАЛТ 5

Зохистой арга, хэвлэл мэдээллийн арга хэрэгслийн жишиг жагсаалт

1. Арга гэдэгт дараах сөрөг маркетинг хамаарна:

- Төлбөрт зар сурталчилгаа;
- Хэвлэлийн нийтлэл;
- Сэтгүүлчид, олон нийтийн анхаарлыг татах арга хэмжээ зэрэг хэвлэл; мэдээллийн зориудын арга хэмжээ.

2. Хэвлэл мэдээллийн арга хэрэгсэл гэдэг дараах зүйл хамаарна:

- телевиз;
- радио;
- сонин;
- сэтгүүл;
- Мэдээллийн самбар;
- Цахим арга хэрэгсэл, ж.нь гар утасны мессеж, и-мейл, веб сайт, блог, нийгмийн сүлжээ.

ХАВСРАЛТ 6

Сургалтын төрлүүдийн жишиг жагсаалт:

- Чиг баримжаа олгох сургалт, уулзалтууд (тамхины шалтгаант өвчнийг дийлж гарсан хүмүүстэй хийх);
- Олны өмнө ярих ур чадвар олгох сургалт (тамхины хяналтын талаар хэвлэл мэдээллийн болон бусад байгууллагатай харьцдаг хүмүүст зориулсан);
- Ухуулга нөлөөллийн ур чадвар олгох болон хэвлэл мэдээллийн сургалт;
- Харилцаа холбоо тогтоох талаар сургалт;
- Кампанит ажил төлөвлөх сургалт;
- Үнэлгээний сургалт;
- Үе тэнгийнхний боловсрол;
- Тамхины сөрөг үр нөлөө, тамхины хяналтын үйл ажиллагааны үр ашгийн талаар сургалт;
- Тамхины хяналтын асуудлаар хэвлэл мэдээллийнхэнд зориулсан сургалт;
- Сургуульд тулгуурласан сургалтын хөтөлбөр, залуучуудын дунд тамхидалтаас сэргийлэх хөтөлбөрт тамхи үйлдвэрлэгчдийн зүгээс үзүүлэх нөлөөллийн талаар чадавхи бэхжүүлэх сургалт;
- Фейсбүүк зэрэг нийгмийн цахим харилцааны талаарх сургалт.

ХАВСРАЛТ 7

Шинэлэг аргын жишиг жагсаалт:

- Цахим сургалт, вэбд суурилсан аргууд;
- Үе тэнгийнхний боловсрол;
- Сургагч багшийн сургалтын загвар;
- Нөхөн үржихүйн эрүүл мэндийн хөтөлбөр (үүнд мөн ХДХВ/ДОХ-ын хөтөлбөр хамаарна), өвчний хяналтын хөтөлбөр (ж.нь, ДОТС), мансууруулах бодис (согтууруулах ундаа, хар тамхи)-ын хэрэглээтэй тэмцэх хөтөлбөр, орчны хөтөлбөр зэрэг нэгэнт тогтсон хэрэгжиж буй хөтөлбөрийн хүрээнд давхар сургах арга.

ХАВСРАЛТ 8

Тодорхой зорилтот бүлэгт чиглэсэн сургалтын аргуудын жишиг жагсаалт

Сургалтын өөр өөр аргууд дараах үзүүлэлтээр хоорондоо ялгаатай. Үүнд:

- (a) Байршил (боловсролын байгууллага, ажлын байр, эрүүл мэндийн байгууллага);
- (b) Сургалт зохион байгуулж буй мэргэжилтнүүд (эмнэлийн ажилтан, нийгмийн ажилтан, багш, зөвлөгч);
- (c) Арга ажиллагаа (радио, лекц зэрэг зорилтот хүн амд хүрэх арга).

ХАВСРАЛТ 9

Боловсрол, харилцаа холбоо, сургалт, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрт татан оролцуулах иргэний нийгмийн гишүүдийн жишиг жагсаалт

- Эмэгтэйчүүдийн, залуучуудын, орчны, хэрэглэгчдийн зэрэг төрийн бус байгууллагууд;
- Сан;
- Мэргэжлийн байгууллагууд;
- Хувийн байгууллага;
- Эрдэм шинжилгээний байгууллага;
- Сургалтын байгууллага;
- Эрүүл мэндийн байгууллага.

ХАВСРАЛТ 10

Олон улсын түвшинд тайлагнах мэдээллийн жишиг жагсаалт

- Боловсрол, харилцаа холбоо, сургалт, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн;
- Үндэсний түвшинд хийсэн үнэлгээний үр дүн;
- Тухайн улсад хамгийн зохистой болох нь тогтоогдсон стратеги;
- Тулгамдсан асуудлууд;
- Тамхи үйлдвэрлэгчдийн үйл ажиллагаа.

(Долоодугаар нэгдсэн хуралдаан, 2010 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр)